

ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2023 ОНЫ 5 ДУГААР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

ТӨРИЙН УДИРДЛАГЫН ЧИГЛЭЛЭЭР:

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.21 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, 22 дугаар зүйлийн 22.3, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтуудыг удирдлага болгон сумын Засаг даргын 2023 А/56 захирамжаар 5 дугаар сарын 19-нд болсон байгалийн гамшигт үзэгдлийн улмаас учирсан хохирол, малын хорогдлыг тогтоох, хариу арга хэмжээ авч ажиллах үүрэг бүхий ажлын хэсгүүдийг томилон ажиллууллаа. Мөн сумын Засаг даргын А/57 дугаар захирамжаар байгалийн гамшгийн улмаас үхэж хорогдсон малыг нэг цэгт бөөгнүүлэх ариутгаж булах 2 устгалын цэгийг тогтоон, уг цэгүүдэд үхэж хорогдсон малыг цуглуулан булах ажил хийгдэж байна. Дээрх 2 ажилд нийт 37 төрийн албан хаагч 4 техниктэй ажиллаж байна. Урьдчилсан байдлаар 5 багийн 312 малчин өрхийн 33667 толгой мал хорогдсон мэдээ гараад байна. Байгалийн гамшигт үзэгдлийн үед сумын Онцгой комисст иргэд төөрсөн 7 дуудлага ирснийг авран хайх ажиллагаа явуулж, эсэн мэнд олж гэрт нь хүргэлээ.

5 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд Сүхбаатар аймагт зохион байгуулагдсан 13 сумын "СҮХБААТАР АЙМАГ-ХӨГЖИЛД ХАМТДАА" хөрөнгө оруулалт, хөгжлийн чуулганд тус сум оролцлоо. Чуулганд зориулж сумын Засаг даргын нөөц сангаас 3,25 сая төгрөгийг зарцуулсан байна.

Багуудын иргэдийн нийтийн хурал энэ сарын 15-17-ны өдрүүдэд товлон хуралдлаа. Хуралд "Газар дэлхий" ХХК-ны төлөөлөгчид оролцож, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй холбоотой асуудлаар иргэдэд мэдээлэл хүргэв. Мөн иргэд ОНХС-гийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх ажлын санал асуулга, өвөлжөө, хаваржааны газар эзэмшүүлэх талаар хэлэлцлээ.

Удирдлагын академиас зохион байгуулдаг "Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалт"-д 3 төрийн албан хаагч, "Төрийн албанд томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалт"-д 1 албан хаагч тус тус хамрагдаж байна.

5 дугаар сард E-mongolia оператороос 7 иргэн лавлагаа мэдээлэл авсан байна. Сумын вэб хуудсанд цаг үеийн болон сарын ажлын мэдээ, нийт 3 удаа мэдээлэл оруулсан.

5 дугаар сарын байдлаар сумын нийт суурин хүн ам 3479, өрх 1003 байна. 2023 он гарсаар шинээр төрсөн 30 , нас барсан 3 хүн бүртгэгдсэн.

5 дугаар сарын байдлаар Хоршоо хөгжүүлэх сан нь нийт 15 зээлдэгчтэй байгаа ба хугацаа хэтэрсэн чанаргүй 6 зээлдэгч, хэвийн 9 зээлдэгч байна. Сан нь нийт 149,405,396 төгрөгийн үлдэгдэлтэй байна. 1 зээлдэгч зээлээ бүрэн хаасан. Хугацаа хэтэрсэн зээлдэгчийн 2 зээлдэгч үндсэн зээлийн үлдэгдлээс 2,700,000 мянган төгрөг хийсэн байна.

Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан "Сумын шилдэг үлгэр жишээ гэр бүл шалгаруулах" цахим уралдаан 5 сарын 10-19-ны хооронд зарлаж сумын 22 гэр бүл оролцсон.

Түвшинширээ суман дахь "Түвшин-Амьдрал" АА бүлгийн нээлтийн үйл ажиллагаа зохион байгуулагдлаа.

ТӨСӨВ САНХҮҮГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

5 дугаар сарын 8-нд төсөвт байгууллагуудын сарын төсөв, гүйцэтгэл, орон нутгийн орлогын төлөвлөгөөний гүйцэтгэл, ОНХСангийн төлөвлөгөөний гүйцэтгэл, бусад мэдээ мэдээллийг шилэн дансанд шивж оруулсан.

Нийгмийн даатгалын НД 8, НД7 /ажиллагсдын цалин тооцооны хуудас/ тайлангууд мөн татварын ТТ 11, ТТ 12 буюу үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын тайлангуудыг гарган интернетэд шивэн цахимаар илгээсэн. Орон нутгийн ерөнхий орлого, татварын орлогын гүйцэтгэлийн мэдээг шилэн дансанд шивсэн. Төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээг гаргаж Санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ДЭД БҮТЭЦ, БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР:

Сумын ОНХС-гийн хөрөнгөөр 2023 онд хийгдэхээр төлөвлөгдсөн ажлуудаас энэ сард "Соёлын төвийн ЛЕД дэлгэц худалдан авах" ажил 100% хийгдэж, техник тоног төхөөрөмжийг бүрэн угсруулан хүлээж аваад байна. "Цахилгаан дамжуулах агаарын шугамын өргөтгөл"- 71,0 сая төгрөгийн ажил-10%-тай явагдаж байна. Хогийн цэгт хог асгах шинэ нүх ухуулах ажлын тендерт "Мандах оройн товгор" ХХК шалгарч, гэрээ байгуулах эрх олгогдсон. "Худаг уст цэг олшруулах, гүн өрмийн худаг гаргуулах" ажлын тендер зарлагдаад байна. Шууд худалдан авах ажлуудаас "Хогийн цэгийг цэгцлэх-20 сая" ажил хийгдээд байгаа.

Сумын Засаг даргын 2023 оны А/42 “Бэлчээрийн мэрэгч үлийн цагаан огтонотой тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” захирамжаар бэлчээрийн мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг сумын хэмжээнд зохион байгуулж ажиллалаа. Уг ажилд албан байгууллага, малчид, иргэд нийт-250 орчим хүн оролцож, 2.8 тонн хорыг нийт 107000 га талбайд цацсан.

Нохой устгалын ажлыг 5-р сарын 6-7-ны өдрүүдэд зохион байгуулж 94 нохой устгаж, ажлын хөлс болон шатахуунд 2540000 / хоёр сая таван зуун мянган / төгрөг зарцуулсан байна.

Өвөлжилт, хаваржилтын хүндрэлээс шалтгаалан үхсэн малын сэг зэмийн устгалыг нийтийг хамарсан ажлын шугамаар 20 иргэнийг түр ажлын байраар ханган хийсэн ба нийт 6256 малын сэг зэм устгаад байна.

Сумын төвийн бүх ногоон байгууламжийн модыг тогоолж усалгаа хийлээ.

Сумын төвд 1 ангилан ялгах стандартын хогийн сав шинээр хийж байршууллаа.

Долоо хоног бүрийн Даваа гарагт хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн судалгааг программд тогтмол оруулж байна.

НИЙГМИЙН ХАЛАМЖ, ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:

НИЙГМИЙН ХАЛАМЖ: 2023 оны 05-р сард 2021-2022 онд төсөл хөтөлбөрт хамрагдсан хөтөлбөрт хамрагдсан 11 иргэн хувиарын дагуу 2,676,500 мян. төгрөг төвлөрүүлэхээс 4 иргэн 1006500 мян. төгрөгийн ХЭДС-ийн тоот дансанд төвлөрүүлсэн.

ХЭДС-аас олгогдох “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа”-2 иргэн, “Иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэг”-1 иргэн, “Ахмад мэргэжилтэний зөвлөх үйлчилгээ”-1, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг”-2 хөтөлбөрт хамрагдсан 6 иргэнээс 5 иргэнийг цахим сургалтанд хамруулж санхүүгийн дэмжлэгийн гэрээг хийж 5 иргэнд 28 сая төгрөгийн санхүүжилтэд хамруулсан.

ХЭДС-аас зарлагдсан “Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-т хамрагдах хүсэлтэй 6 малчин өрхөөс 5 өрхийг сумын АДЗ-ийн шийдвэрээр сонгон шалгаруулж, шалгарсан 5 өрхийн холбогдох баримт бичгийг бүрдүүлэн аймгийн ХХҮГ-т хүргүүлсэн.

"Ажлын байрыг дэмжих хөтөлбөр"-ийн нийтийг хамарсан ажлыг зохион байгуулахад ХХҮГ болон сумын ЗДТГ хамтран "Сэг зэм" цэвэрлэх ажлыг 2023 оны 05-р сарын 15-ны өдрөөс эхлэн ажлын 10 хоног явагдаж байна.

Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгаанд сумын хэмжээнд 7 өрх хамрагдах ба хөдөөгийн 3 өрхийн байршлын газрын зураг гарган холбогдох баримтуудыг бүрдүүлэн ажиллаж байна.

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт тусламжийн үйлчилгээнд хамрагдсан 6 иргэнд 395640 төгрөгийн мэдээллийг "Нөхөн олголтын" жагсаалтаар гарган, нөхөн олгуулсан.

ОНОТХҮ-ний бүлгийн төслийг сумын АДЗ-өөр шалгаруулан "Хүнсний ногоо" бүлгийн төслийн баримт бичгийг бүрдүүлэн буцалтгүй 1500,0 мян төгрөгийг олгуулах ажлыг хийсэн.

Сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг хийж нийгмийн халамжийн тэтгэвэрт шинээр 2 иргэнийг хамруулсан.

05-р сард Нийгмийн халамжийн ehalamj системид нийгмийн халамжийн тэтгэвэрт сунгалт-3 иргэн, шинээр-2 иргэн, өдрийн үйлчилгээнд-10 ахмад, Цалинтай ээж хөтөлбөрийн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсаны тэтгэмжид 9 иргэнд, Жирэмсэн эхийн тэтгэмжид 8 иргэнд, нийт 32 иргэний мэдээллийг бүртгэж тэтгэвэр тэтгэмжид бүрэн хамруулсан.

НИЙГМИЙН ДААТГАЛ: Эрүүл мэндийн даатгалд 14 иргэний 1137500 төгрөг , сайн дурын даатгалд 29 хүний 3420859 төгрөгийн орлого орсон. 5 дугаар сарын тэтгэвэрт 2 банкаар дамжуулан 425 хүнд 211208624 сая төгрөгийн тэтгэвэр олгосон. Шинээр 5 иргэний тэтгэврийн материал хүлээн авч, тэтгэвэр тогтоогдсон. 3 хүнд 9047028 төгрөгийн жирэмсэн амаржсаны тэтгэмж олгосон. 1 хүнд 29754 төгрөгийн хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж олгогдсон.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Сургуулийн үйл ажиллагааг эцэг эх асран хамгаалагчдад сурталчлах "Хамтын хөгжил-Бидний амжилт" тайлант өдөрлөгийг зохион байгууллаа. Тайлант өдөрлөгт 200 гаран эцэг эх болон төрийн байгууллагын төлөөлөл, суралцагчид оролцлоо.

Сургуулийн аварга шалгаруулах гар бөмбөгийн тэмцээнийг 6-8 дугаар анги, 9-12 дугаар анги гэсэн ангиллаар, эрэгтэй эмэгтэй төрлөөр зохион байгууллаа.

“Сурагч -1 өдөр” өдөрлөгийг зохион байгууллаа. Энэхүү өдөрлөг нь сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, сурагч багшийн ажлыг ойлгох, хамтарч ажиллах боломжийг нээсэн үйл ажиллагаа боллоо. Нийт давхардсан тоогоор 64 сурагч энэ үйл ажиллагаанд оролцлоо.

Боловсролын үнэлгээний төвөөс байгууллагын болон багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний бичгийн шалгалтыг ЕБСургуульд хуваарийн дагуу зохион байгууллаа.

Тус сумын 2-5 насны 326 хүүхдээс 308 хүүхэд тус цэцэрлэгт хамрагддаг ба 94,5%-ийг хамруулж байна. 5 настай хүүхдийн хамрагдалт өдрийн бүлэгт 80 хүүхэд хамруулж байгаа бол 9 хүүхэд өөр газарт, тойргийн бус 2 хүүхэд хамрагдаж байна. Цэцэрлэгийн хамрагдалтын цэвэр жин 79%, бохир жин 94,5%-тай байна. Энэ нь өмнөх хичээлийн жилийн хамран сургалтаас 13,5%-аар ахисан үзүүлэлттэй байна.

Сургуульд элсэн суралцсан 84 хүүхдэд сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгааг хийж нэгтгэхэд математикийн энгийн тооцоолол- 82,2%, Хэл яриа-70,7%, Байгаль, нийгмийн орчин-82,1%, Дүрслэх урлаг-73,6%, Нийгэмшихүй- 85,5%, Хөгжим- 67%, Хөдөлгөөн, эрүүл мэнд-76,7%-тай үнэлэгдсэн байна. Цаашид 75% - аас бага үнэлэгдсэн чадваруудыг нэмэгдүүлэхийн тулд сургалт үйл ажиллагааны төлөвлөлтөд тусгаж, өдөр тутмын зориуд болон хөгжөөн баясах, тоглоомын цаг, танин мэдэхүйн үйл ажиллагаар дамжуулан хүүхэд бүрийн чадварыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах, хүүхдийн сурах үйл оролцоог дэмжин, тэгш хүртээмжтэй чанартай зохион байгуулах, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангах, залгамж холбоог сайжруулах зорилгоор Ерөнхий боловсролын сургуультай хамтран “ЗУРГААН НАСТАНГ ЗУГААТАЙ СУРГАЯ” хөтөлбөрт үйл ажиллагааг зохион байгууллаа. Уг үйл ажиллагаагаар ХЭЛ ЯРИА сургалтын чиглэлээр СӨБ-ын багш нээлттэй хичээл заасан бол 3 бүлгийн хүүхдүүдийн эзэмшсэн мэдлэг чадвар, дадал хэвшлийн үзүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 125 хүүхэд хамрагдсан. 5-6 настай хүүхдийг хөгжүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, сургуульд чанартай бэлтгэх арга туршлага суралцах, хуваалцах зорилгоор багш нарын дунд “Бие биеээсээ суралцацгаая” хэлэлцүүлэг өрнүүлж өөр өөрийнхөө арга туршлагаас бусдадаа хуваалцлаа. Мөн сургуулийн сургалтын менежер бэлтгэл бүлгийн эцэг эхчүүдэд “Таны хүүхэд сургуульд бэлэн үү” сэдэвт сургалтыг нийт 58 эцэг эхэд зохион байгуулсан бол бэлтгэл бүлгийн 80 хүүхэд сургуульд элсэн орох урилгаа хүлээн авлаа. ЕБС-ийн бага ангийн багш “Стеам” сургалтыг СӨБ болон ЕБС-ын багш нарт зохион байгууллаа.

СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн, “Алсын хараа -2050” хөтөлбөр, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд “Эмгүйгээр эрүүлжье” нийтийн цэнгээнт бүжгийн анхан шатны сургалтыг 7 хоног бүрийн мягмар, пүрэв гаригуудад давхардсан тоогоор 113 ахмадуудыг хамруулж, 16 тоот дасгал хөдөлгөөн, стандарт бүжгүүдийг зааж сургав.

Соёлын төвийн дэргэдэх нийтийн номын сан нь энэ сард 41 уншигчдад ном олгох үйлчилгээг үзүүлж ажилласан.

“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд “Судар-Эгшиглэн” төслийн нээлтийн үйл ажиллагааг угтан “Номтой иргэн-Ирээдүйн гайхамшиг” номын хандивын аяныг нийт албан байгууллагуудын дунд зарлаж одоогийн байдлаар СӨБ, ЕБСургууль, ЭМТ, Соёлын төв гэх албан байгууллагууд хамрагдаад байна.

Олон улсын музейн өдрийг “Музейн хүч нөлөө” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан мөн Монгол Улсын Ерөнхийлөгч 2003 онд жил бүрийн 05 дугаар сарын эхний ням гаргийг Монголын үндэсний бичиг үсгийн баярын өдөр болгон гаргасан зарлигийн дагуу Соёлын төвийн бүртгэл мэдээллийн санч 2023.05.08-05.18 өдрүүдэд төлөвлөсөн ажлын дагуу ЗДТГ-ын ажилтан албан хаагч нарт “Монгол түүхэн бичгүүд” Соёлын өвийн талаар, Соёлын биет бус өвийн төрөл оньсон тоглоомыг хэрхэн тоглох талаар сургалтыг зохион байгууллаа.

5 дугаар сард Соёлын төвийн дэргэдэх есөн төрлийн дугуйлан цагийн хуваарийн дагуу 108 хүүхдийг хамруулан хичээллэж байна.

Хүүхдийн урлагийн боловсролыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд Монгол улсын хүүхэлдэйн театр, Түмэнцогт сумын соёлын төвийн хамт олон “Өнхрүүш” хүүхэлдэйн жүжгээр сумын нийт 308 хүүхэд багачуудад соёл урлагийн явуулийн үйлчилгээг хүргэлээ.

Бүх нийтийн соёлын боловсруулыг дээшлүүлэх, соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой “Соёлын сэргэлт 2023” аяны бэлтгэл ажлыг хийж хүүхэд багачууддаа бие биелэгээ, домог бүжгийг зааж сургаж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторийн нийт үзлэг 151, алсын дуудлага 9, гэрийн дуудлага 0, хэвтэн эмчлүүлэгч 16, халдвартай бүсэд хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөн байхгүй.

Олон Улсын эмч нарын баярын өдрийг тохиолдуулан сумын Эрүүл мэндийн төвд олон жил ажилласан Ч.Үржиннацаг эмчийн ар гэр үр хүүхдүүдийн хамт, үе үеийн эх баригч нарыг алдаршуулах “Хүйн ээж - 101” арга хэмжээг зохион байгууллаа.

Сар болгон хийгддэг товлолын вакциныг 48 хүүхдэд хийгээд байна.

5 дугаар сард сэргээн засах эмчилгээнд: Бумба – 75, УВЧ – 32, Бариа -35, НУТ – 22, Искра – 4 иргэнд үйлчилсэн.

Тухайн сард Лабораторын хийсэн шинжилгээ үйлчилгээ: сахар – 35, шээсний ерөнхий шинжилгээ – 39, биохими-1, элгэний В, С вирус– 17, БЗХӨ – 9, серологи-10, ковид-20 шинжилгээ тус тус хийгдсэн байна.

Тайлан нэгтгэсэн:

ХЭЗМэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын дарга

Ц.Ренчинмядаг